ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

# ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

**Аудитын код: СНАГ-2025/006/НА-СТА-ТТЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2025 он | Санхүү, нийцлийн аудитын газрын захирал,<br>тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг<br>Утас: 261663 Цахим хаяг:naranchimegts@audit.gov.mn<br>Аудитын менежер: Д.Энхдалай<br>Утас: 260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Ц.Энхжаргал<br>Утас: 261740 Цахим хаяг: enkhjargalts@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.04.11 № 01/1483

танай ____________-ны №____________-т

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Э.ТӨРБАЯР ТАНАА

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Иргэний нисэхийн ерөнхий газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Сөрөг дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн мэдэгдэхүйц нөлөөллийн улмаас 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС)-ын дагуу үнэн зөв толилуулаагүй байна.

**Сөрөг санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан аудитын сөрөг дүгнэлтийн суурь болоход хангалттай бөгөөд зохистой гэдэгт итгэж байна.

Иргэний нисэхийн ерөнхий газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн нийт 353,424.6 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайлан материаллаг хэмжээгээр буруу илэрхийлэгдсэн, өргөн тархалттай байгаа нь Төсвийн тухай хуулийн 5, 6, 8, 22, 54, 69 дүгээр зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4, 18, 19, 20 дугаар зүйлийн холбогдох заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, тохиолдсон байх, ангилал, оршин байх, үнэлгээ ба хуваарилалт, толилуулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Үүнд:

- Харьяа салбар, нэгжийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй нийт 306,290.9 сая төгрөгийн алдаа, зөрчил нь өмнөх оноос 112 дахин өссөн;
- Удаан жилийн насжилттай 14,084.5 сая төгрөгийн авлага, 1,733.7 сая төгрөгийн өглөгийг барагдуулах ажил зохион байгуулаагүй, шийдвэрлээгүй;
- Өөрийн хөрөнгөөр барьсан 13,070.3 сая төгрөгийн 2 барилгыг авлагын дансанд бүртгэсэн;
- Мөнгөн гүйлгээний тайлангаас тохируулгын дүнгээр тайлан бэлтгээгүйгээс орлого, зарлагын гүйцэтгэлийг хянах, баталгаажуулах боломжгүй байна.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант оны нийт орлогын 93.2 хувь буюу 230,851.8 сая төгрөгийг агаарын навигацийн орлого, 6.4 хувь буюу 15,736.9 сая төгрөгийг бусад орлого, 0.4 хувь буюу 1,159.0 сая төгрөгийг буулт, хөөрөлт, зорчигч үйлчилгээний орлого эзэлж байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Япон Улсын засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн болон Монгол Улсын Засгийн газрын төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн Олон улсын шинэ нисэх онгоцны буудлын хөрөнгийг 2019 онд бүртгэхдээ зарим хөрөнгийн үнэлгээ, тоо ширхэгийг зөрүүлж бүртгэснийг тайлант онд ТӨБЗГ-ын 2024 оны 86 дугаар тогтоолоор залруулж бүртгэсэн байна. ИНЕГ нь 2022 онд концессын гэрээний дагуу 1,038,713.0 сая төгрөгийн хөрөнгийг Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт ХХК-д ашиглуулахаар хүлээлгэн өгсөн байна. Тайлант онд Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт ХХК-д ашиглуулж байгаа хөрөнгийн жагсаалтад орсон өөрчлөлтийг эцэслэн баталгаажуулаагүй байна.

Мөн төсөл арга хэмжээ нь хэрэгжээгүй 2010-2021 онуудад хийсэн 1,835.0 сая төгрөгийн зураг төсвийн ажил, 2011 оноос эхлэн өнөөдрийг хүртэл ашиглалтад ороогүй Бүсийн нислэгийн удирдлагын төвийн 17,836.3 сая төгрөгийн дуусаагүй барилгын асуудлыг шийдвэрлээгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Засгийн газрын 2024 оны 193 дугаар “Төрийн өмчит хуулийн этгээд байгуулах тухай” тогтоолоор Иргэний нисэхийн үндэсний төв Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийг байгуулж, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр Иргэний нисэхийн ерөнхий газрыг тогтоосон байна. Иргэний нисэхийн ерөнхий газрын балансаас агаарын навигаци, нисэх буудал, нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой хөрөнгө, холбогдох баримтыг Иргэний нисэхийн үндэсний төвийн балансt шилжүүлэх ажлыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн зохион байгуулахаар болжээ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн нэгтгэсэн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ Я.САМБУУНЯМ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

*Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | 2023 оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---|---|---|
| **Эргэлтийн хөрөнгийн дүн** | 151,554,575.6 | 130,166,555.0 |
| Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө | 53,542,635.0 | 61,529,880.6 |
| Авлага | 51,841,554.4 | 49,517,488.6 |
| Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 477,605.1 | 360,511.2 |
| Бараа материал | 20,851,589.7 | 18,752,627.1 |
| Бусад эргэлтийн хөрөнгө | 24,841,191.4 | 6,047.5 |
| **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | 1,776,779,957.2 | 1,599,157,010.2 |
| Үндсэн хөрөнгө | 1,259,443,213.6 | 1,096,528,851.0 |
| Биет бус хөрөнгө | 480,767,927.9 | 478,768,370.2 |
| Хойшлогдсон татварын хөрөнгө | 2,003,787.5 | 3,733,812.2 |
| Дуусаагүй барилга | 34,565,028.2 | 20,125,976.8 |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,928,334,532.8** | **1,729,323,565.2** |
| **Нийт өр төлбөр** | 29,601,554.5 | 27,100,371.5 |
| **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | 5,322,641.0 | 4,576,523.6 |
| Өглөг | 5,315,094.0 | 4,568,638.2 |
| Урьдчилж орсон орлого | 7,547.0 | 7,885.4 |
| **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | 24,278,913.5 | 22,523,847.9 |
| Хойшлогдсон татварын хөрөнгө | 2,984,577.2 | 2,981,313.2 |
| Урьдчилж орсон орлого - Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар | 21,294,336.3 | 19,542,534.7 |
| **Цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 1,898,732,978.3 | 1,702,223,193.7 |
| Засгийн газрын хувь оролцоо | 1,898,732,978.3 | 1,702,223,193.7 |
| Өмч /төрийн/ | 1,993,506,509.0 | 1,876,824,127.0 |
| Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/ | 42,425,126.3 | 36,009,163.0 |
| Хуримтлагдсан үр дүн | (137,198,657.0) | (210,610,096.3) |
| **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **1,928,334,532.8** | **1,729,323,565.2** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

*Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | 2023 оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---|---|---|
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН** | 162,959,311.4 | 251,383,394.7 |
| ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 159,991,835.2 | 247,472,612.0 |
| Нийтлэг татварын бус орлого | 159,991,835.2 | 247,472,612.0 |
| ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 2,967,476.2 | 3,910,782.7 |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | 225,176,923.1 | 318,610,061.4 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 225,176,923.1 | 318,610,061.4 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 211,576,923.1 | 238,610,061.4 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 74,286,889.8 | 93,605,764.4 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 9,546,400.1 | 11,924,407.4 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 3,325,606.6 | 3,507,091.0 |
| Хангамж, бараа материалын зардал | 5,499,610.7 | 4,844,377.7 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 3,259,352.5 | 4,262,957.2 |
| Томилолт, зочны зардал | 1,590,897.0 | 2,520,894.6 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 114,068,166.4 | 117,944,569.1 |
| ТАТААС | 8,600,000.0 | - |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 5,000,000.0 | 80,000,000.0 |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН** | (62,217,611.7) | (67,226,666.7) |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | 2,955,230.5 | 6,828,860.5 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 9,900,003.0 | 15,169,221.8 |
| ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ДҮН | 656,699.9 | - |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН** | (69,819,084.1) | (75,567,028.0) |

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

*Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | 2023 оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---|---|---|
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | 155,527,953.0 | 253,491,520.4 |
| ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 152,560,476.8 | 249,580,737.7 |
| Нийтлэг татварын бус орлого | 152,560,476.8 | 249,580,737.7 |
| ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 2,967,476.2 | 3,910,782.7 |
| **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | 141,056,741.2 | 236,976,614.9 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 141,056,741.2 | 236,976,614.9 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 123,641,726.5 | 156,893,543.2 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 73,760,856.9 | 94,780,410.8 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 13,164,585.4 | 11,690,075.5 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 4,522,522.9 | 4,120,329.3 |
| Хангамж, бараа материалын зардал | 4,988,866.0 | 6,560,330.7 |
| Нормативт зардал | 350,149.0 | - |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 3,414,682.3 | 5,861,349.2 |
| Томилолт, зочны зардал | 1,614,467.0 | 2,605,215.8 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 19,879,839.9 | - |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 1,945,757.1 | 31,275,831.9 |
| ХҮҮ | 42,804.5 | 83,071.7 |
| ТАТААС | 5,901,923.7 | - |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 11,470,286.5 | 80,000,000.0 |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | 14,471,211.8 | 16,514,905.5 |
| ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 438,118.2 | 836,650.5 |
| ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 3,984,569.3 | 9,364,310.4 |
| ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 3,984,569.3 | 9,364,310.4 |
| Дотоод эх үүсвэрээр | 3,984,569.3 | 9,364,310.4 |
| **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | (3,546,451.0) | (8,527,659.9) |
| НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 10,924,760.8 | 7,987,245.6 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 42,616,874.2 | 53,541,635.0 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 53,541,635.0 | 61,528,880.6 |

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Нийт дүн | Цөөнхийн хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---|---|---|---|
| **2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | 1,958,977,185.1 | | 1,958,977,185.1 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 1,958,977,185.1 | | 1,958,977,185.1 |
| Өмчид гарсан өөрчлөлт | 9,574,877.4 | | 9,574,877.4 |
| Зарласан ногдол ашиг | | | |
| **Тайлант үеийн үр дүн** | (69,819,084.1) | | (69,819,084.1) |
| **2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | 1,898,732,978.4 | | 1,898,732,978.4 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 1,898,732,978.4 | | 1,898,732,978.4 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | (120,942,756.8) | | (120,942,756.8) |
| **Тайлант үеийн үр дүн** | (75,567,028.0) | | (75,567,028.0) |
| **2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **1,702,223,193.7** | | **1,702,223,193.7** |

## 2.5 Төсвийн гүйцэтгэлийн тайлан

*Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

/төгрөгөөр/

| Данс код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | - | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **3,910,782,700.00** | **3,910,780,700.00** | **2,000.00** | 100.0 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,910,782,700.00** | **3,910,780,700.00** | **2,000.00** | 100.0 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **3,565,820,000.00** | **3,565,818,000.00** | **2,000.00** | 100.0 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **2,732,357,100.00** | **2,732,357,100.00** | - | 100.0 |
| 210101 | Үндсэн цалин | 2,089,324,000.00 | 2,089,324,000.00 | - | 100.0 |
| 210102 | Нэмэгдэл | 510,829,900.00 | 510,829,900.00 | - | 100.0 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 132,203,200.00 | 132,203,200.00 | - | 100.0 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **341,544,700.00** | **341,544,700.00** | - | 100.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 232,250,300.00 | 232,250,300.00 | - | 100.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 27,323,600.00 | 27,323,600.00 | - | 100.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 21,858,900.00 | 21,858,900.00 | - | 100.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 5,464,700.00 | 5,464,700.00 | - | 100.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 54,647,200.00 | 54,647,200.00 | - | 100.0 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **93,195,000.00** | **93,195,000.00** | - | 100.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 24,525,000.00 | 24,525,000.00 | - | 100.0 |
| 210302 | Түлш, халаалт | 46,107,000.00 | 46,107,000.00 | - | 100.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 22,563,000.00 | 22,563,000.00 | - | 100.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **79,753,000.00** | **79,753,000.00** | - | 100.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 16,105,700.00 | 16,105,700.00 | - | 100.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 39,240,000.00 | 39,240,000.00 | - | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 19,306,100.00 | 19,306,100.00 | - | 100.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,101,200.00 | 5,101,200.00 | - | 100.0 |
| **2105** | **Нормативт зардал** | **29,430,000.00** | **29,428,000.00** | **2,000.00** | 100.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 29,430,000.00 | 29,428,000.00 | 2,000.00 | 100.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **38,926,100.00** | **38,926,100.00** | - | 100.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 29,430,000.00 | 29,430,000.00 | - | 100.0 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 6,984,700.00 | 6,984,700.00 | - | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 2,511,400.00 | 2,511,400.00 | - | 100.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **29,430,000.00** | **29,430,000.00** | - | 100.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 29,430,000.00 | 29,430,000.00 | - | 100.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **29,889,100.00** | **29,889,100.00** | - | 100.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 11,281,500.00 | 11,281,500.00 | - | 100.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 4,414,500.00 | 4,414,500.00 | - | 100.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,765,800.00 | 1,765,800.00 | - | 100.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 753,400.00 | 753,400.00 | - | 100.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 9,417,600.00 | 9,417,600.00 | - | 100.0 |
| 210807 | Газрын төлбөр | 1,275,300.00 | 1,275,300.00 | - | 100.0 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 981,000.00 | 981,000.00 | - | 100.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **191,295,000.00** | **191,295,000.00** | - | 100.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 29,430,000.00 | 29,430,000.00 | - | 100.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 161,865,000.00 | 161,865,000.00 | - | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **344,962,700.00** | **344,962,700.00** | - | 100.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 200,100,400.00 | 200,100,400.00 | - | 100.0 |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | 200,100,400.00 | 200,100,400.00 | - | 100.0 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **144,862,300.00** | **144,862,300.00** | - | 100.0 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 2,226,400.00 | 2,226,400.00 | - | 100.0 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 125,568,000.00 | 125,568,000.00 | - | 100.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 17,067,900.00 | 17,067,900.00 | - | 100.0 |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **3,910,782,700.00** | **3,910,782,700.00** | - | 100.0 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **3,910,782,700.00** | **3,910,782,700.00** | - | 100.0 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 3,910,782,700.00 | 3,910,782,700.00 | - | 100.0 |
| | АЖИЛЛАГСДЫН ТОО | 2196 | 2170 | - | 100.0 |
| | Удирдах ажилтан | 18 | 18 | - | 100.0 |
| | Гүйцэтгэх ажилтан | 2178 | 2152 | - | 100.0 |

## 3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар залруулагдаагүй нийт 353,427.8 сая төгрөгийн 85 зөрчил илэрснээс 3.2 сая төгрөгийн 1 алдааг залруулж, 6.3 сая төгрөгийн зөрчилд 7 төлбөрийн акт тогтоож, 294,041.2 сая төгрөгийн зөрчилд 34 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх 59,377.1 сая төгрөгийн 43 зөвлөмж өгсөн.

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| № | Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнэлэс: Залруулсан | | Үнэлэс: Залруулаагүй | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Өглөгийг дутуу тусгасан. | 1 | 3,200.0 | | | 1 | 3,200.0 | 1 | 3,200.0 | | | | |
| | Дүн | 1 | 3,200.0 | | | 1 | 3,200.0 | 1 | 3,200.0 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| № | Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | ИНЕГ | 11 | 47,133,723.5 | | | 9 | 33,234,924.3 | 2 | 13,898,799.2 |
| 2 | ИНЕГ – аппарат | 7 | 88,030,610.6 | | | 5 | 72,742,067.4 | 2 | 15,288,543.2 |
| 3 | ИНҮТ | 4 | 185,991,771.9 | | | 3 | 185,991,771.9 | 1 | - |
| 4 | ИНҮТ – аппарат | 7 | 21,432,308.3 | | | 3 | 1,287,908.3 | 4 | 20,144,400.0 |
| 5 | ГТҮШХА | 5 | 5,682,873.8 | | | 2 | 50,582.2 | 3 | 5,632,291.6 |
| 6 | НХНАА, НЖЗШНА, НУТА, ОХЗЛ, НХҮА, НМҮА | 4 | 2,752,750.5 | | | 1 | 222,728.3 | 3 | 2,530,022.2 |
| 7 | ЖСЗА | 5 | 354,182.0 | | | 3 | 261,143.4 | 2 | 93,038.6 |
| 8 | НАБХА | 4 | 780,209.2 | | | 2 | 45,441.8 | 2 | 734,767.4 |
| 9 | ШХА | 2 | 82,815.3 | | | | | 2 | 82,815.3 |
| 10 | БУОУНБ | 4 | 327,162.9 | | | 2 | 99,796.0 | 2 | 227,366.9 |
| | Аймгийн нисэх буудлууд | | | | | | | | |
| 1 | Баянхонгор нисэх буудал | 3 | 1,145.1 | 1 | 400.0 | | | 2 | 745.1 |
| 2 | Баян-Өлгий нисэх буудал | - | - | | | | | | |
| 3 | Булган нисэх буудал | 10 | 742,108.7 | 2 | 1,080.7 | 2 | 92,823.2 | 6 | 648,204.9 |
| 4 | Говь-Алтай нисэх буудал | 3 | 11,190.0 | | | 1 | 11,190.0 | 2 | - |
| 5 | Дорнод нисэх буудал | - | - | | | | | | |
| 6 | Дундговь нисэх буудал | 4 | 30,608.5 | | | 1 | 817.4 | 3 | 29,791.1 |
| 7 | Завхан нисэх буудал | - | - | | | | | | |
| **8** | Өвөрхангай нисэх буудал | 1 | - | | | | | 1 | - |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **9** | Өмнөговь нисэх буудал | 4 | 61,129.9 | | | | | 4 | 61,129.9 |
| 10 | Хөвсгөл нисэх буудал | 2 | 7,524.5 | 1 | 2,302.1 | | | 1 | 5,222.4 |
| 11 | Ховд нисэх буудал | 2 | 1,750.0 | 1 | 1,750.0 | | | 1 | - |
| 12 | Хэнтий нисэх буудал | 2 | 757.6 | 2 | 757.6 | | | | |
| 13 | Сүхбаатар нисэх буудал | - | - | | | | | | |
| 14 | Тосонцэнгэл нисэх буудал | - | - | | | | | | |
| 15 | Увс нисэх буудал | - | - | | | | | | |
| | **НИЙТ ДҮН** | **84** | **353,424,622.3** | **7** | **6,290.4** | **34** | **294,041,194.2** | **43** | **59,377,137.7** |

3.2 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар нийт 33,718.9 сая төгрөгийн 44 зөрчил илэрснээс 20,301.5 сая төгрөгийн 9 албан шаардлага хүргүүлж, 13,417.4 сая төгрөгийн 35 зөвлөмж өгсөн.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| № | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | ИНЕГ | 2 | - | | | | | 2 | - |
| 2 | ИНЕГ – аппарат | 8 | 20,584,534.6 | | | 5 | 19,603,822.6 | 3 | 980,712.0 |
| 3 | ИНҮТ | 2 | 3,593,479.0 | | | | | 2 | 3,593,479.0 |
| 4 | ИНҮТ – аппарат | 4 | 1,393,281.8 | | | 2 | 657,173.7 | 2 | 736,108.1 |
| 5 | ГТҮШХА | 1 | 439,270.2 | | | | | 1 | 439,270.2 |
| 6 | НХНАА, НЖЗШНА, НУТА, ОХЗЛ, НХҮА, НМҮА | 3 | 4,050,526.6 | | | | | 3 | 4,050,526.6 |
| 7 | ЖСЗА | 4 | 64,423.8 | | | | | 4 | 64,423.8 |
| 8 | НАБХА | 4 | 2,429,906.6 | | | | | 4 | 2,429,906.6 |
| 9 | ШХА | 5 | 454,763.9 | | | 1 | - | 4 | 454,763.9 |
| 10 | БУОУНБ | 3 | 259,681.7 | | | | | 3 | 259,681.7 |
| | Аймгийн нисэх буудлууд | | | | | | | | |
| 1 | Баянхонгор нисэх буудал | 1 | 36,949.9 | | | | | 1 | 36,949.9 |
| 2 | Баян-Өлгий нисэх буудал | - | - | | | | | | |
| 3 | Булган нисэх буудал | - | - | | | | | | |
| 4 | Говь-Алтай нисэх буудал | - | - | | | | | | |
| 5 | Дорнод нисэх буудал | - | - | | | | | | |
| 6 | Дундговь нисэх буудал | 5 | 108,696.5 | | | | | 5 | 108,696.5 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | Завхан нисэх буудал | - | - | | | | | | |
| 8 | Өвөрхангай нисэх буудал | 1 | 40,505.0 | | | 1 | 40,505.0 | | |
| 9 | Өмнөговь нисэх буудал | - | - | | | | | | |
| 10 | Хөвсгөл нисэх буудал | - | - | | | | | | |
| 11 | Ховд нисэх буудал | - | - | | | | | | |
| 12 | Хэнтий нисэх буудал | - | - | | | | | | |
| 13 | Сүхбаатар нисэх буудал | - | - | | | | | | |
| 14 | Тосонцэнгэл нисэх буудал | - | - | | | | | | |
| 15 | Увс нисэх буудал | 1 | 262,871.3 | | | | | 1 | 262,871.3 |
| | **НИЙТ ДҮН** | **44** | **33,718,890.9** | | | **9** | **20,301,501.3** | **35** | **13,417,389.6** |